



## БНЭУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД РАЖНАТ СИНГХИЙН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ӨНДӨРЛӨЛӨӨ

Монгол, Энэтхэг Улсын хооронд стратегийн түншлэл тогтоосноос хойш Энэтхэгийн Батлан хамгаалах яамны зүгээс хийж буй анхны айлчлалын эзэн БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх тэргүүтэй хүндэт төлөөлөгчдийн айлчлал өнөөдөр өндөрлөлөө.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын урилгаар манай улсад айлчилсан ноён Сингх Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяртай уулзалт хийж, хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа цэргийн бүх түвшний харилцан айлчлал, Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалт хийх, цэргийн мэргэжилтэн сургах, мэргэжил дээшлүүлэх, энхийг сахиулах болон хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг хэлбэрээр амжилттай хөгжиж буй харилцаагаа улам бэхжүүлэх зэрэг асуудлаар хэлэлцэн тохирсон юм.

Мөн БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат

Сингхийг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нар хүлээн авч уулзлаа. Эрхэм хүндэт зочид айлчлалын үеэр ҮБХИС-д зочлон Кибер аюулгүй байдлын сургалтын төвийн нээлтийн ёслолын ажиллагаа, Зайсан дахь Монгол-Энэтхэгийн Найрамдлын сургуулийн шав тавих ёслолд оролцсоноос гадна Гандантэгчэнлин, Бэтүб хийдүүдээр зочилсон юм.

Энэхүү айлчлал нь Монгол, Энэтхэг Улсын цэргийн салбарт хамтран ажиллах, бүс нутгийн хэмжээнд цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд цаашид хоёр улсын Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэн, өргөжүүлэн хөгжүүлэхэд хамтран ажиллахад чухал нөлөөтэй явдал боллоо.

БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх тэргүүтэй хүндэт төлөөлөгчид ийнхүү Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалаа өндөрлөж, нутаг буцлаа.



## ОРОН ТООНЫ БУС ХЭВЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧ НАРТ АЖЛЫН ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Захиргааны удирдлагын хэлтсээс харьяа нэгтгэл, ангиудын Соёл хүмүүжлийн албаны дарга, зааварлагч нартай уулзаж, зарим асуудлаар санал солилцож, ажлын чиглэл өглөө.

Захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэлийн төлөөлөгч, олон нийттэй харилцах офицер, ахлах дэслэгч Д.Болормаа уулзалтын эхэнд "2020 онд ЗХЖШ-ын даргын тушаалаар нэгтгэл, анги бүрт орон тооны бус хэвлэлийн төлөөлөгчийн ажлыг хавсран гүйцэтгэх албан тушаалтнууд томилогдсон. Тэр үед УИХ-ын сонгууль болох гэж байсантай холбогдуулан хуулийн офицерууд голчлон томилогдсон байдаг бөгөөд ажлын шаардлага, төсөөтэй байдал зэргээс шалтгаалан өдгөө Соёл хүмүүжлийн албаны дарга, зааварлагч нар үндсэн үүргийнхээ хажуугаар

үг үсгийн алдаа, утга найруулгад анхаарах зэргийг дурдаад нэгтгэл, ангийн дотооддоо эрхлэн гаргадаг сонинуудын чанар, хүртээмжийн тухай ярилцаж, бие бүрэлдэхүүндээ ЗХЖШ-ын пэйж хуудас болон веб сайтад нэвтэрч, тогтмол мэдээлэл авах талаар сурталчлах, дэмжлэг үзүүлэхийг хүслээ.

Энэ үеэр гаднын хэвлэл мэдээллийн байгууллагатай хэрхэн харилцах, Зэвсэгт хүчний нэр хүндэд халтай ярилцлага, үл ойлголцлыг олон нийтийн сүлжээгээр гаргахгүй байхад анхаарах, "Соёмбо" редакттай хамтран ажиллаж, алба хаагчдаа алдаршуулахад идэвх санаачилгатай байх, орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нарыг мэргэшүүлж, тогтвортой ажиллуулахад нь хамтран ажиллахыг захилаа.

Мөн нэгтгэл, ангийнхаа үйл ажиллагаа,



гүйцэтгэж байна" гээд энэ хугацаанд Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нар алба хаагчдаа сурталчлах, үйл ажиллагаатай холбоотой илт мэдээ мэдээллээ командлалд явуулж хэвшсэн гэдгийг тодотгов.

Мөн тэрээр 2022 оны эхний гурван улиралд нэгтгэл, ангиудаас ирүүлсэн сурталчилгааны мэдээллийн тоо, чанарын үзүүлэлтийг сонирхуулж, цаашид анхаарах асуудлаа харилцан ярилцав. Тухайлбал, байнгын бүрэлдэхүүний сургалт бэлтгэлтэй холбоотой мэдээллээс татгалзах, цэргийн дүрэмт хувцасны зөрчилгүй гэрэл зураг ирүүлж байх,

хугацаат цэргийн болон цэргийн гэрээт алба хаагчдаа сурталчилсан мэдээ мэдээллийг тогтмол ирүүлж хэвшсэн Зэвсэгт хүчний 327, 186 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албаны дарга нарт дурсгалын зүйл гардуулж, орон тооны бус хэвлэлийн төлөөлөгчөөр хамгийн тогтвортой ажиллаж байгаа Зэвсэгт хүчний 016, 120, 256 дугаар нэгтгэл, ангийн офицеруудад талархал дэвшүүлэв.

Төгсгөлд нь "Мэдээлэл, талх хоёр шинэхэн тусмаа амттай" гэдгийг санаж, мэдээ мэдээллээ дор бүр нь бэлтгэн командлал болон "Соёмбо" редакцияд явуулахад идэвх санаачилгатай ажиллахыг хүсэв.

## ГАДНА ТАЛБАЙН ҮЗҮҮЛЛЭГТЭЭ ЗАСВАР ХИЙЛЭЭ



Монгол цэргийн музей өвөл сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд олон ажил хийж гүйцэтгэж байна. Өнгөрсөн өдрүүдэд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын дэмжлэгтэйгээр Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн бие бүрэлдэхүүн музейн гадна ил талбайн үзүүлэг болох онгоц, зэвсэг техникүүдийн өнгө үзэмжийг сайжруулах, засварлан будах ажлыг хийлээ.

Цаашдаа ч мөн гадна ил талбайн бусад үзүүлэгүүдийг будах, засварлах ажлуудыг үргэлжлүүлэн хийх болно. Энэ ташрамд, монгол цэргийн түүхэн өв соёлыг хамгаалах, арчлан тордох үйлсэд нэгдсэн Агаарын цэргийн командлал болон Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн бие бүрэлдэхүүнд талархал илэрхийлье.

Цахим шууданд

ЦЭРЭГ ЭРСИЙН АМЬ НЭГ  
ЦЭРГИЙН ХҮНИЙ ЗЭВСЭГ АМЬ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги, Зенитийн артиллерийн дивизион хугацаат цэргийн алба хаагчдынхаа өөрийгөө хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрөл бүрийн дугуйлангуудыг хичээллүүлдэг бөгөөд бие биеэсээ суралцаж, авьяасаа нээн хөгжүүлсээр байгаа билээ. Үүний зэрэгцээ модон эдлэл, гар урлалын дугуйланг 10 хоногийн хугацаатай алба хаагчдын дунд хичээллүүлэн 2021-2022 оны сургуулийн жилийн ангийн захирагчийн нэрэмжит төгсөлтийн шалгалтыг угтан хүн нэг бүрийн зэвсэг болох 7,62 мм-ийн АКМ бууны модон эдлэлийн өнгө үзэмжийг сайжруулан засаж, янзаллаа.

Энэ үйл ажиллагаа нь дараа дараагийн цэргийн албанд татагдан ирэх дайчдаа цэргийн эрдэмд шамдан суралцаасай гэж хүсэн хугацаат цэргийн алба хааж байгаа залуус өөрсдийн санаачилгаар, өөрсдийн гараар хийж бүтээж байгаа үйл явдал юм. Цэргийн алба хааж байгаа залуус цэргийн өдөр тутмын үйл ажиллагаанаас амьдралд хэрэгтэй олон зүйлүүд сурч мэдсэний нэг илрэл нь энэ үйл ажиллагаагаар харагдаж байна.

Дивизионы соёл хүмүүжлийн офицер ахмад Ц.ТУНГАЛА

ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАЖ БАЙНА

Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалын дагуу Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, харьяа нэгтгэл, ангиуд 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангахаар долоон чиглэлээр 1000 гаруй ажил төлөвлөснөөс 70 орчим хувийн хэрэгжилттэй байна.

Зэвсэгт хүчний Хуурай замын командлагчийн удирдамжийн дагуу тус командлалын Материал техникийн хэлтсийн бүрэлдэхүүн өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг эрчимжүүлж, хэрэгжилтийг бүрэн хангуулахаар Зэвсэгт хүчний 016, 014, 119, 120, 326 дугаар нэгтгэл, ангиудад шалган, туслах ажлыг явуулаад байна.

Шалган туслах ажлын явцад тус ангиудын өвс, хадлан, төмс хүнсний ногоогоо хурааж авах, жилийн хэрэгцээний мал, мах бэлтгэх, хэрэгцээт нүүрсийг татан авах зэрэг олон ажлын хэрэгжилтийн явцтай танилцсан юм.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН  
АЛБАНААС ХҮССЭН СУРГУУЛЬДАА  
ТЭНЦСЭН ОЮУТНУУД



багш мэргэжлээр, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Т.Гандбадра БНХАУ-д Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Ц.Одбаяр Үндэсний Батлан хамгаалах Их сургуульд, Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч, түрүүч Ц.Билэгжаргал Дотоод хэргийн Их сургуульд тус тус элсэж, өдгөө сургуульдаа сурцгааж байна. Мөн Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, ахлах байлдагч Б.Билгүүн хугацаат цэргийн алба хааж байхдаа цахимаар суралцаж, дээд сургуулиа дүүргэж чадсан билээ.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа хэд хэдэн залуу элсэлтийн ерөнхий шалгалтаа өгч, хүссэн сургуульдаа тэнцсэн билээ. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хугацаат цэргийн албаны сургалт бэлтгэлийнхээ хажуугаар цахимаар суралцах, элсэлтийн ерөнхий шалгалтад өөрийгөө бэлтгэх бололцоог хангаж өгсөн учраас хэд хэдэн түрүүч, байлдагч оюутан болж чадсан юм. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, дэд түрүүч Б.Баясгаланбаатар Монгол Улсын Багшийн Их сургуульд Монгол хэлний

ЭНЭ ӨДӨР ДЭЛХИЙН ТҮҮХЭНД



1915 оны есдүгээр сарын 7.

Анхны танкийг угсрав Бяцхан Уилли буюу "Little Willie" хочит анхны танкийг 1915 оны есдүгээр сарын 6-д угсарч дуусжээ. 14 тонн жинтэй, цагт

ердөө 3.2 км зам туулах чадвартай танкийг Англид бүтээсэн байна. Анхны танк жижиг болхи байсан ч маш хурдан сайжирч дайны талбарыг өөрчилсөн билээ.

1991 оны есдүгээр сарын 7. ЗХУ Балтын тэнгисийн орнуудын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөв Дэлхийн хоёрдугаар дайны үеэр Балтын тэнгисийн Латви, Литва, Эстони улсууд руу довтлон эзэлсэн ЗХУ 1991 оны есдүгээр сарын 6-д тус орнуудын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрчээ.

